

Төсөл.

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын оны сарын
-ны өдрийн / дугаар хамтарсан
тушаалын хоёрдугаар хавсралт

**БАЙНГЫН АСАРГАА ШААРДЛАГАТАЙ 0-16 ХҮРТЭЛХ НАСНЫ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ӨВЧИН, ГЭМТЛИЙН ЖАГСААЛТ**

№	Өвчний нэр, үе шат	Өвчний олон улсын код. (Өвчний олон улсын ангилал ICD-10-ын дагуу)	Эмчлэн эрүүлжүүлж, нөхөн сэргээх хугацаа	Өвчний заалт. Шалгуур үзүүлэлт
1. Бөөрний мэс заслын өвчин				
1.1	Төрөлхийн давсагны өмнөд ханагүй	Q64.0	Мэс заслын дараа 12-36 сар хүртэл	Давсаг, тулгуур эрхтэний болон бусад эрхтэний эмгэг хавсарсан тохиолдолд орно.
1.2	Шээдэг сүвийг нөхөн сэргээх мэс заслын эмчилгээ үр дүнгүй бөөрний дутагдал (олон дахисан шээдэг сүвний нарийсал, гипосади)	N99.0	Мэс заслын дараа 12-36 сар хүртэл	Олон үе шаттай хагалгаа хийгдэж дуусаагүй, гэмтлийн улмаас аарцаг яс хугарсан, шээдэг сүв тасарсан тохиолдолд орно.
1.3	Бөөр, шээс дамжуулах замын сөөргөө	N13.0	Мэс заслын дараа 12-24 сар хүртэл	2 бөөр болон давсганд гуурстай байх хугацаанд орно.
1.4	Давсагны саажилттай, нефростоми ба цистостомийн гуурстай	N31.0	Мэс заслын дараа 12-24 сар хүртэл	Хэвлийн өмнөд ханыг цоолж давсганд байнгын гуурстай байдаг ба давсагны мэдрэлийн гаж хөгжил, мэдрэлийн хатангаршил-эмчлэгдэх хугацаа тодорхойгүй үед орно.
2. Бөөр, шээс дамжуулах замын өвчин				
2.1	Бөөрний дутмагшил, төгсгөлийн шат	N18.0	12-36 сар	Бөөрний өвчний эцсийн 4, 5 дугаар шатанд бөөр орлуулах эмчилгээ шаардлагатай тул бөөр шилжүүлэн суулгатал байнгын асаргаа шаардагдана. Бөөрний үйл ажиллагаа

				эргэшгүйгээр алдагдсан, гемодиализ эмчилгээ хийгдэж байх үед орно.
2.2	Бөөрний архаг дутмагшил, тодорхойгүй	N18.9	12-36 сар	Төрөлхийн бөөр, шээсний замын гажиг дээр үүссэн бөөрний архаг дутмагшилтай, гемодиализ эмчилгээ хийгдэж байх үед орно.
2.3	Бөөрний сувганцрын үйл ажиллагааны алдагдлаас үүссэн эмгэг	N25.9	12-36 сар	Гемодиализ эмчилгээ хийгдэж байх үед орно.
2.4	Нефротик хамшинж	N04	12-36 сар хүртэл	Төрөлх нефрозын хамшинж олон дахилттай, дааврын хамааралтай, дааварт тэсвэртэй болсон тохиолдолд орно.
3. Мэс заслын өвчин				
3.1	Уушгины архаг идээт үрэвсэл	J41	Мэс заслын дараа 12 сар хүртэл	Мэс заслын аргаар шийдэгдээгүй тохиолдолд төрөлжсөн мэргэжлийн эмчийн дүгнэлтийг үндэслэн хэлэлцэж, заасан хугацааны хүрээнд сунгаж болно.
3.2	Цэсний сувгийн төрөлхийн битүүрэл	K83.1	Мэс заслын дараа 12-36 сар хүртэл	
3.3	Үүдэн венийн даралт ихсэх хамшинж	K74.6	Мэс заслын дараа 12-36 сар хүртэл	
3.4	Ясны архаг идээт үрэвсэл	M86.2	Мэс заслын дараа 6 сар хүртэл	
3.5	Нарийн бүдүүн гэдэсний цорго гаргасан	K63.1	Мэс заслын дараа 12 сар хүртэл	
3.6	Хошног шулуун гэдэсний гаж хөгжил	Q42.2	Мэс заслын дараа 12 сар хүртэл	
3.7	Улаан хоолойн химийн түлэгдэл	T26.1	Мэс заслын дараа 12-24 сар хүртэл	
3.8	Улаан хоолойн битүүрэл	Q39	Пластик мэс заслын дараа 12-24 сар хүртэл	
3.9	Элэг цэсний хагалгааны дараах байдал	K91	Мэс заслын дараа 12 сар	
3.10	Хэвлийн гялтангийн түгээмэл үрэвсэл	K65.0	Мэс заслын дараа 6 сар хүртэл	
3.11	Бөөрний өмөн хагалгааны дараах байдалтай /Вильямсийн хавдар/	C64.0	12-36 сар	
3.12	Ил давсаг	Q64.1	12-36 сар	

3.13	Улаан хоолойн төрөлхийн нарийсал нөхөн сэргээх эмчилгээнд үр дүнгүй (тураал)	K22	Мэс заслын дараа 12-24 сар хүртэл	Хооллох боломжгүй, байнга гуурсаар шингэн зүйлээр хооллож байгаа бол орно. Зүрх судас, хоол боловсруулах эрхтэнүүдийн үйл ажиллагааны алдагдалд орсон үед орно. Сунгаж болно.
3.14	Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний дараах суулгацын үйл ажиллагааны алдагдсан (элэг, бөөр, зүрх, нойр булчирхай, чөмөг шилжүүлэн суулгасан)	T86	12-36 сар	Суулгац эрхтэн үндсэн өвчинд өртөх, ондооших, дархлаа дарангуйлах эмчилгээний гаж нөлөө г.м. шалтгаанаар суулгасан эрхтэний үйл ажиллагаа алдагдсан бол орно.
3.15	Эмийн болон хими (хавдрын) эмчилгээний дараах элэгний архаг үрэвслүүд	K74.4	12-36 сар	Зөвхөн элэгний хатуурал (цирроз) үүссэн үед орно.
3.16	Нарийн бүдүүн гэдэсний цоорхой	K63.1-K63.2	Мэс заслын дараа 12 сар хүртэл	Амин чухал эрхтэнүүдийн үйл ажиллагааны дутагдалд орсон тохиолдолд орно. Энэ үед сунгаж болно.
4.Нүдний өвчин				
4.1	0-16 насны хүүхдүүдэд зохих эмчилгээ хийлгэсний хамгийн сайн харж байгаа нүдний харааны чадал 0,05 (3/60)-аас бага эсвэл харааны талбайн алдагдал 10°-аас дотогш харахад хүргэж байгаа нүдний бүх төрлийн өвчин эмгэг, гэмтэл, хавдар зэргийг хамруулан оруулах		12-24 сар	Ямар ч шалтгааны улмаас ДЭМБ-ын тодорхойлолтоор хараагүй гэсэн ангилалд хамаарагдаж буй өвчтөнүүд орно.
5.Чих, хамар, хоолойн өвчин				
5.1	2 чихний төрөлхийн дутуу хөгжил	Q16.0 H90.5	12 сар	Мэс засалд орох хүртэл байнгын асаргаанд байх ба 4-8 насны хооронд суваг нээх мэс заслыг аль нэг чихэндээ заавал хийлгэнэ. 0-6 насанд мэс засал хийгдээгүй тохиолдолд асаргаа сунгагдахгүй. Эхний суваг нээх мэс заслын эмчилгээний асаргааны хугацаанд дараагийн суваг нээх (нөгөө чихэнд) мэс засал хийгдвэл сүүлчийн

				<p>мэс засал хийгдсэн өдрөөс асаргааг дахин 12 сар сунгана.</p> <p>6-12 насны хооронд суваг нээлгэх мэс засал хийлгэлгүй, чамархайн ясны сонсголын аппарат суулгасан тохиолдолд хагалгаанд орсноос хойш 12 сар байнгын асаргаанд хамрагдах бөгөөд дахин сунгагдахгүй.</p>
5.2	2 талын дуу хүлээн авах хэлбэрийн тодорхойгүй дүлий	H.90.5	12-36 сар	<p>Дуу хүлээн авах хэлбэр (мэдрэл мэдрэхүйн)-ийн III зэргийн, шалтгаан тодорхойгүй сонсгол бууралттай 3 хүртэлх насны хүүхдэд байнгын асаргаа шаардлагагүй ба бусад эрхтэний хавсарсан эмгэгтэй үед чих, хамар, хоолойн эмчийн дүгнэлтийг үндэслэн асаргааг тогтоож болох ба энэ хугацаанд онош тодруулж эмчилгээг шийдвэрлүүлнэ.</p> <p>3 хүртэлх насанд сонсгол нөхөн сэргээх мэс засал хийгдсэн бол эмчилгээний хэлбэр сонсгол-хэл заслын эмчилгээний үр дүнгээс шалтгаалж мэс засал хийлгэснээс хойш асаргааг 36 сараар сунгана.</p>
5.3	2 талын дуу хүлээн авах хэлбэрийн хүнд зэргийн бууралт	H90.3	12-36 сар	<p>Төрөлхийн болон дуу хүлээн авах хэлбэрийн 2 талын IV зэрэг (хүнд хэлбэр)-ийн дүлийрэлтийн үед эмчилгээний асуудал бүрэн шийдэгдтэл эхний 36 сар асаргаанд байх бөгөөд сонсгол нөхөн сэргээх мэс засал хийгдсэн бол мэс заслын дараах сонсгол сайжралтын үр дүнгээс хамааран 36 сараар асаргааг сунгах ба чих, хамар, хоолойн хяналтын эмчийн дүгнэлтийг үндэслэнэ.</p>
5.4	Дунгийн суулгацтай хүүхэд төрөлхийн 2 талын дуу хүлээн авах хэлбэрийн хүнд зэргийн дүлий (1 талд тавьсан бол)	H90.5	12-36 сар	<p>Мэс засал эмчилгээ хийлгэх хүртэл байнгын асаргаанд байх ба дунгийн суулгац, чамархайн ясны сонсголын аппарат суулгасан тохиолдолд мэс заслын дараа 36 сар байнгын асаргаа шаардагдана.</p> <p>Мэс засал эмчилгээний дараах асаргааны хугацаанд хийгдэх сонсгол нөхөн сэргээх, хэл заслын эмчилгээнүүдийн үр дүн нь үг таних</p>

				чадвар үгийн тестээр 50%-аас доош байгаа нь сонсгол судлалын эмчийн дүгнэлтээр нотлогдсон тохиолдолд асаргааг дахин 36 сар сунгана.
5.5	Дунгийн суулгацтай хүүхэд (төрөлхийн 2 талын дуу хүлээн авах хэлбэрийн хүнд зэргийн дүлий) 2 талд тавьсан бол	H90.5	12-36 сар хүртэл	Эхний дунгийн суулгац эмчилгээний асаргааны хугацаанд дараагийн дунгийн суулгац (нөгөө чихэнд)-ын мэс засал хийгдвэл сүүлчийн мэс засал хийгдсэн өдрөөс асаргааг дахин 36 сар хүртэл сунгах ба асаргааны хугацаанд хийгдэх сонсгол нөхөн сэргээх, хэл заслын эмчилгээнүүдийн үр дүн нь үг таних чадвар үгийн тестээр 70%-аас доош байгаа нь сонсгол судлалын эмчийн дүгнэлтээр нотлогдсон тохиолдолд асаргааг дахин 36 сар хүртэл сунгана.
5.6	Хамрын төрөлхийн гажиг (Гадна хамаргүй хоан битүү гэх мэт, хамрын төрөлхийн гаж хөгжил)	Q31 Q30	12 сар хүртэл	Хамрын төрөлхийн гажиг (Гадна хамаргүй хоан битүү гэх мэт, хамрын төрөлхийн гаж хөгжил)-ийн нөхөн сэргээх мэс заслын дараа 12 сар байнгын асаргаанд байх бөгөөд дахин сунгагдахгүй.
5.7	Мөгөөрсөн хоолойд гуурс тавих эмчилгээ эмчилгээ хийгдсэн	J38	12-36 сар	Мөгөөрсөн хоолойд гуурс тавих эмчилгээ хийгдсэн тохиолдолд мэс заслын дараа 36 сар байнгын асаргаанд байх бөгөөд цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавьсан тохиолдол болгоны дараа байнгын асаргааг 36 сараар сунгана. Хяналтын эмч цагаан мөгөөрсөн хоолойд дахин гуурс тавих заалт гаргаагүй тохиолдолд асаргааг сунгахгүй.
5.8	Мөгөөрсөн хоолойд амьсгалуулах байнгын гуурстай байх	J38	12-36 сар	Мөгөөрсөн хоолойд гуурс тавих эмчилгээ хийгдсэн тохиолдолд мэс заслын дараа 36 сар байнгын асаргаанд байх бөгөөд цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавьсан тохиолдол болгоны дараа байнгын асаргааг 36 сараар сунгана. Хяналтын эмч цагаан мөгөөрсөн хоолойд дахин гуурс тавих заалт гаргаагүй тохиолдолд асаргааг сунгахгүй.

				Байнгын гуурстай байх тохиолдолд гуурс тавьсны дараа 36 сар хүртэл асаргаа шаардагдана.
6.Мэдрэлийн өвчин				
6.1	Хүүхдийн тархины саа, саажилт	G80	24-36 сар	Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний II-V түвшинг багтаана (GMFCS). Хөгжлийн дэмжлэг, сэргээн засалтын үр дүнд үндэслэж сунгана.
6.2	Эмэнд тэсвэртэй эпилепси, мөн эпилепсийн энцефалопати	G40.2, G40.4, G40.5 ба F07 хавсрах	12-24 сар	Тухайн эпилепсийн хэлбэрт зохистой хоёроос доошгүй эмийн эмчилгээнд эпилепсийн уналт таталтын давтамж багасаагүй, үр дүнгүй байх тохиолдолд “эмэнд тэсвэртэй эпилепси” хэмээх оношийг тавина. Эмэнд тэсвэртэй эпилепсийн уналт таталтын давтамж өндөр байна (ухамсарт ухааны алдагдал бүхий уналтууд сард 4-өөс дээш удаа, ухамсарт ухаан алдахгүй жижиг уналтууд өдөр бүр). Дараах шинжийг агуулсан тархины хүнд эмгэгийг эпилепсийн энцефалопати гэж тодорхойлно: 1) тархины цахилгаан бичлэгт байнга илрэх пароксизм идэвхжил 2) олон хэлбэртэй уналт таталттай, эмэнд тэсвэртэй 3) танин мэдэхүйн хөгжлийн хоцрогдол, төрх үйлийн ба мэдрэлийн голомтот өөрчлөлттэй 4) зарим тохиолдолд эрт үхэлтэй.
6.3	Тархи, нугасны цочмог эмгэгийн дараах үлдэц болох тал биеийн саажилт, дөрвөлсаа, хөлийн хос саа, тэнцвэргүйдэл, хараагүйдэл, сонсголгүйдэл, аарцгийн эрхтэний үйл ажиллагааны алдагдал ба танин мэдэхүйн хөгжлийн саатал	G81, G82, G83, R32, R15	6-12 сар	Менингоэнцефалит, энцефалит, миелит, энцефаломиелит, тархи нугасны хүнд гэмтэл, хавдар, тархи усжилт, харвалт зэрэг бүх төрлийн тархи нугасны гэмтлийн дараах үлдэц байдал багтана. 6-12 сар тутамд хүүхдийн биеийн байдлыг шинээр үнэлэх.

6.4	Сул саажилт, булчингийн хатангирал бүхий мэдрэл-булчингийн даамжрах эмгэг	G12.0, G12.1, G71, G60	12-24 сар	Хүүхэд наснаас эхлэн даамжрах бүх төрлийн миодистрофи, миотонийн дистрофи, гар хөлийн хөдөлгөөнд илт нөлөөлсөн удмын нейропати багтана.
6.5	Үрэвслийн шалтгаант хүнд хэлбэрийн полирадикулоневритийн үлдэц байдал	G61	6 сар	Хүнд хэлбэрийн полирадикулоневритийн дараа үлдэх сул саажилт, бие даах чадвар алдагдсан байх. 6 сар тутамд хүүхдийн биеийн байдлыг шинээр үнэлэх.
6.6	Даамжрах дистонийн эмгэгийн хүнд хэлбэр	G24.1, G24.2	12 сар	Хүүхэд наснаас эхлэх дистонийн эмгэг ихэвчлэн мөчдөөс эхлэн, тархаж, бүх биеийг хамрах, генийн эмгэгтэй холбоотой, хүнд эмгэгийн тоонд багтана.
6.7	Удмын бага тархины тэнцвэргүйдэл	G11		Хүүхэд наснаас эхлэх бага тархины тэнцвэргүйдлийн эмгэг нь ховор тохиолдох, генийн эмгэгтэй холбоотой, аажим даамжрах өвчний тоонд багтана. Тархины олдмол эмгэгийн дараах үлдэц болох тэнцвэргүйдэл үүнд хамаарахгүй.
6.8	Мэдрэлийн тогтолцооны гаж хөгжилтэй холбоотой танин мэдэхүйн өөрчлөлт/хөгжлийн хоцрогдол, хөдөлгөөний эвслийн алдагдал, мөчдийн саажилт, хэл залгиурын саажилт, аарцгийн эрхтэний үйл ажиллагааны алдагдал	Q01, Q05, Q07.0, Q03.1, Q75.0, Q75.8, Q75.8, Q87.0-Q87.8, Q90-Q99	12-36 сар	Үүнд микроцефали, менингоцеле, менингоэнцефалоцеле, спина бифида, краниосиностоз, базилар имресси, атланта-окципитал үений гажиг, Arnold-Chiari гажиг, Dandy-Walker хамшинж г.м. гаж хөгжлийн гажиг бүхий эмгэгүүд багтана. Эдгээрээс гадна Дауны хамшинж, Pradera-Willi, Klinefelter, Turner, Martin-Bell, Rett хамшинж г.м. хромосомын ба генийн гажиг бүхий эмгэг багтана. Өдөр тутмын чадварыг үндэслэн тогтоох ба сунгана.
7.Төрөлхийн гаж хөгжил				
7.1	Төрөлхийн дээд мөчгүй	Q71.0	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний үе шатыг харгалзан шийдвэрлэнэ.
7.2	Төрөлхийн бугалга ба шуугүй; төрөлхийн бугалга ба шуугүй боловч 1 ба 2 талд сарвуутай	Q71.1	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний үе шатыг харгалзан шийдвэрлэнэ.

7.3	Төрөлхийн доод мөчгүй	Q72.0	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний үе шатыг харгалзан шийдвэрлэнэ.
7.4	Төрөлхийн шилбэ ба тавхайгүй	Q72.2	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний үе шатыг харгалзан шийдвэрлэнэ.
7.5	Тархины төрөлхийн том энцефалоцеле	Q01	12-36 сар	Онош батлагдсан бол орно. 12-36 сарын дараа мэргэжлийн эмчийн үнэлгээнд үндэслэж байнгын асаргаа шаардлагатай хугацаа сунгах эсэхийг шийдвэрлэнэ.
7.6	Нугасны төрөлхийн хүнд хэлбэрийн ивэрхий	Q06	12-36 сар	Онош батлагдсан бол орно. 12-36 сарын дараа мэргэжлийн эмчийн үнэлгээнд үндэслэж байнгын асаргаа шаардлагатай хугацаа сунгах эсэхийг шийдвэрлэнэ.
7.7	Тархины төрөлхийн хүнд хэлбэрийн усжилт	Q03.8-Q03.9	12-36 сар	Онош батлагдсан бол орно. 12-36 сарын дараа мэргэжлийн эмчийн үнэлгээнд үндэслэж байнгын асаргаа шаардлагатай хугацаа сунгах эсэхийг шийдвэрлэнэ.
7.8	Тавхайн төрөлхийн гаж хөгжил буюу майга тавхайн хүнд хэлбэр нэг болон хоёр талд	Q66	Мэс засал эмчилгээнд үр дүнгүй тавхайн үйл ажиллагаа сэргэх боломжгүй гишгэх чадвар бүрэн алдагдсан бол 12-36 сар. Тавхай засах эвийн эмчилгээ хоногт 12 цагаас дээш тасралтгүй хийгдэх хугацаанд 12 сар	Димеглогийн үнэлгээгээр майга тавхайн зэргийг үнэлнэ. Тус үнэлгээ нь майга тавхайн тавхай жийсэн шагайн үений хөшүүн байрлал, өсгий дотогш эргэх, өлмий дотогшлох гэсэн 4 бүтцийн өөрчлөлтийг үнэлэх ба тус бүр 1-4 оноо нийт 0-20 оноогоор үнэлнэ. Тавхай жийсэн шагайн үений хөшүүн байрлалыг сагитал тэнхлэгээр, өсгий дотогш эргэснийг фронтал тэнхлэгээр, тавхайн дунд хэсгээр дотогш эргэх болон өлмий дотогшлох хэв шинжийн гажгийг хөндлөн тэнхлэгээр хэмжилт хийнэ. Хүнд зэрэг оноо 11-15, хэлбэр нь 20°-0° улны нум хэт ихэссэн. Маш хүнд оноо 16-20, хэлбэр нь < 20°-(-20°) булчингийн хэвийн байдал алдагдсан. Энэ 2 тохиолдолд байнгын асаргаанд орно.

7.9	Зүрхний төрөлхийн хавсарсан эмгэгийн хүнд хэлбэр	Q20.0-28.0 Z95	12-36 сар	Зүрхний төрөлхийн хавсарсан гажгууд, 1-3 үе шаттай зүрхний мэс засал шаардлагатай тохиолдлууд орно.
7.10	Зүрхний гажиг, хагалгааны дараах байдал	Q20.0-28.0 Z95	Мэс заслын дараа 12 сар хүртэл	Зүрхний төрөлхийн гажигийн мэс заслын дараах бүх тохиолдлууд орно.
7.11	Зүрхний хавхлага дутуу хаагдах эмгэг	Q23.1	12-36 сар	Цус эргэлтийн хямралтай хүнд хэлбэр нь орно.
7.12	Өрөөсөн мөч мухар гар хөлгүй	Q71.0-Q73.8	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний үе шатыг харгалзан шийдвэрлэнэ.
7.13	Нойр булчирхайн дутуу хөгжил	Q45.0	Онош батлагдсанаас хойш 12-36 сар	Хүнд хэлбэрийн үед орно.
7.14	Биеийн гүнд байрладаг судаснуудын гаж хөгжил (биеийн нэг тал нь өсөлтгүй хүүхэд)		12-36 сар	Биеийн нэг тал нь өсөлтгүй үед орно.
7.15	Төрөлхийн сарвуугүй нэг ба хоёр талд	Q71	12-36 сар	Хоёр талд сарвуугүй бол 16 нас хүртэл, нэг талд сарвуугүй бол 6 нас хүртэл асаргаанд орно.
8.Зүрх судас, холбогч эдийн өвчин				
8.1	Зүрхний төрөлхийн хавсарсан хөх гажгууд	Q20.0-28.0	12-36 сар	Зүрхний төрөлхийн хавсарсан гажгууд, 1-3 үе шаттай зүрхний мэс засал шаардлагатай тохиолдлууд орно.
8.2	Тогтолцооны чонон яр (хүнд зэрэг)	M32	12-36 сар	Тогтолцооны чонон яр өвчний дотор эрхтэн, мэдрэлийн тогтолцооны эмгэг хавсарсан хэлбэрүүд орно.
8.3	Дерматомиозит	M33	12-36 сар	Хүнд хэлбэр нь орно.
8.4	Тогтолцооны склеродермийн хүнд хэлбэр	M34	12-36 сар	Тогтолцооны склеродермийн бусад эрхтнийг хамарсан хүнд хэлбэр нь орно.
8.5	Дилатационная кардиомиопатия (тэлэгдлийн, бөглөрөлт, рестриктив)	I42.0-I42.2	Мэс заслын дараа 12-36 сар хүртэл	Кардиомиопатийн бүх хэлбэрүүд, зүрхний дутагдлаар хүндэрсэн тохиолдолд орно.
8.6	Уушгины анхдагч даралт ихсэх эмгэг	I27.0	Мэс заслын дараа 12-36 сар хүртэл	Уушгины анхдагч даралт ихсэлт, зүрхний дутагдлаар хүндэрсэн тохиолдлууд орно.
8.7	Хүүхдийн өсвөр үеийн хэрлэг төст үений үрэвсэл Үйлдлийн чадвар алдаглтын 3,4 дүгээр зэрэг	M08	Онош батлагдсанаас хойш 12 сар	Үйлдлийн чадвар алдалтын 3, 4 дүгээр зэрэг буюу өөрөө өөртөө үйлчлэх боломжгүй, хөдөлгөөн хийх боломжгүй байх үед орно. Онош батлагдаагүй бол орохгүй.

9.Хоол боловсруулах тогтолцооны өвчин				
9.1	Ээнэгшил алдагдсан элэгний хатуурал	K74	12-36 сар	Цаашид элэг шилжүүлэн суулгах эмчилгээнд хамрагдах хүртэл асаргаа шаардлагатай.
10.Булчирхайн өвчин				
10.1	Чихрийн шижин хэв шинж-1	E10	12-36 сар	Онош батлагдсан бүх тохиолдол нь орно.
10.2	Ахондродисплази	Q77.4	12-36 сар	Онош батлагдсан бүх тохиолдол нь орно.
10.3	Бамбай булчирхайн төрөлхийн дутал	E00	12-36 сар	Бие бялдар ба оюун ухааны хөгжлийн хүндэвтэр ба хүнд зэргийн хоцрогдолтой бол орно.
10.4	Пангипопитуитаризм	E23.0	12-36 сар	Онош батлагдсан бүх тохиолдол нь орно.
10.5	Адреногениталь хамшинж	E25	12-36 сар	Давс алдах хэлбэр, эрших хэлбэр, даралт ихсэх хэлбэр, хавсарсан хэлбэр нь орно.
10.6	Бэлгийн эрт бойжил	E30.1	12-36 сар	Онош батлагдсан бүх тохиолдол нь орно.
11.Цусны эмгэг				
11.1	Цусны хавдар: Хурц лимфобластик лейкоз	C91.0	30 сар	Тасагт идэвхтэй хими эмчилгээний 6-7 сар, кабинетэд барих эмчилгээний 2 жил буюу 24 сар. 30 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
11.2	Хурц миелобластик лейкоз	C92.0	18 сар	Тасагт идэвхтэй хими эмчилгээний 6-7 сар, кабинетэд барих эмчилгээний 1 жил буюу 12 сар. 18 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
11.3	Архаг миелолейкоз	C92.1	15 сар	Тасагт идэвхтэй хими эмчилгээний 3 сар, кабинетэд барих эмчилгээний 1 жил буюу 12 сар. 15 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
11.4	Төрөлхийн цус бүлэгнэлтийн эмгэг, Гемофили А	D66	12-36 сар	Хүнд хэлбэрийн байнгын цусархагшилтай насан туршийн эмгэг.
11.5	Гемофили В	D67	12-36 сар	Хүнд хэлбэрийн байнгын цусархагшилтай.

11.6	Виллебрандын өвчин	C68.0	12-24 сар	Хүнд хэлбэрийн байнгын цусархагшилтай.
11.7	Апластик анеми-Төлжилтгүй цус багадалт	D60	12-36 сар	Хүнд хэлбэрийн байнгын цусархагшилтай.
11.8	Шалтгаан тодорхойгүй ялтсан эс цөөрөх эмгэг	D69.3	12-24 сар	Хүнд архаг цусархагшилтай хэлбэр.
11.9	Цус задралын цус багадалт	D59	12-24 сар	Хүнд архаг цус задрах хэлбэр.
11.10	Гистоцитоз Х –нэг бөөмт эсийн хорт хавдар	C96.1	18 сар	Тасагт идэвхтэй хими эмчилгээний 6-7 сар, кабинетэд барих эмчилгээний 1 жил буюу 12 сар. 18 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
11.11	Тунгалгийн хавдар: Хүүхдийн хорт Ходжкины лимфома	C81	12 сар	Тасагт идэвхтэй хими эмчилгээний 12 сар. 12 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
11.12	Хүүхдийн хорт Ходжкины бус лимфома	C82	30 сар	Тасагт идэвхтэй хими эмчилгээний 6-7 сар, кабинетэд барих эмчилгээний 2 жил буюу 24 сар. 18 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
12.Хавдар				
12.1	Хорт хавдрууд: Нейробластома	C47	18 сар	Мэс засал, хими эмчилгээний 6 сар, барих эмчилгээний 1 жил буюу 12 сар. 18 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
12.2	Ретинобластома	C69.2	12 сар	Идэвхтэй хими эмчилгээний 1 жил буюу 12 сар. 12 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
12.3	Зөөлөн эдийн хавдар	C49.9	12 сар	Идэвхтэй хими эмчилгээний 6 сар, кабинетийн хяналтын 6 сар

				12 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
12.4	Ясны хавдар	C41	30 сар	Тасагт идэвхтэй хими эмчилгээний 6-7 сар, кабинетэд хяналтын 2 жил буюу 24 сар. 30 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
12.5	Юингийн хорт хавдар	C40	30сар	Тасагт идэвхтэй хими эмчилгээний 6-7 сар, кабинетэд хяналтын 2 жил буюу 24 сар. 30 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
12.6	Тархины хорт хавдар	C71	24 сар	Мэс заслын, хими эмчилгээний, кабинетийн хяналтын 2 жил буюу 24 сар. 24 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
12.7	Элэгний хорт хавдар	C22.2	18 сар	Мэс заслын, идэвхтэй хими эмчилгээний 6 сар, кабинетийн хяналтын 1 жил буюу 12 сар. 18 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
12.8	Бөөрний хорт хавдар	C64	18 сар	Мэс заслын, идэвхтэй хими эмчилгээний 6 сар, кабинетийн хяналтын 1 жил буюу 12 сар. 18 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
12.9	Үр хөврөлийн эсийн гаралтай хорт хавдар	C62.9, C56	18 сар	Мэс заслын, идэвхтэй хими эмчилгээний 6 сар, кабинетийн хяналтын 1 жил буюу 12 сар. 18 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
12.10	Өнчин тархины аденом	C75	36 сар	36 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.

12.11	Гистоцитоз Х - нэг бөөмт эсийн хорт хавдар	D76.3	36 сар	36 сарын дараа тухайн өвчний явц, хүндрэлээс хамаарч асаргааг тодорхой хугацаагаар дахин сунгаж болно.
13. Амьсгалын эрхтэний өвчин				
13.1	Амьсгалын эрхтэний амьдралд үл нийцэх гаж хөгжил	Q33	12-36 сар	Гуурс төрөлхийн буруу байрлалтай, дэлбэн дутуу, амьсгалын дутлын хүнд зэргийн үед орно.
13.2	Гуурсан хоолойн багтраа	G45	12 сар	Амьсгалын дутлын 3,4 дүгээр зэрэгтэй бол орно.
13.3	Гемосидероз	J84	12-36 сар	Даамжрах явцтай уушгины архаг өвчин тул амьдрах явцдаа байнгын асаргаанд хамрагдах шаардлагатай. Амьсгалын дутлын 3,4 дугаар зэрэгтэй бол орно.
13.4	Уушгины фиброз	J84.1	12-36 сар	Амьсгалын дутлын 3,4 дүгээр зэрэгтэй бол орно.
14. Сэтгэцийн эмгэг				
14.1	Оюуны хүндэвтэр хомсдол (IQ 35-49)	F71	12-24 сар	Оюуны коэффициент нь 35%-49% байна. Хэл ярианы болон хүний үг яриаг ойлгох чадвар, механик ой тогтоолт, хийсвэр сэтгэхүй сул хөгжилтэй. Төрх үйлийн гүнзгий хямралтай, уналт таталт өгдөг, ухамсарт ухааны баларталтад ордог, хавсарсан бусад эрхтэн системийн мөчдийн саажилт, тэнцвэргүйдэл, хараагүйдэл, сонсголгүйдэл гүнзгий илэрсэн.
14.2	Оюуны хүнд хомсдол (IQ 20-34)	F72	12-36 сар	Оюуны коэффициент нь 20%-34% байна. Хийсвэр сэтгэхүй хөгжөөгүй, Сэтгэлийн хөдөлгөөний илрэл сул, хөдөлгөөн чөлөөтэй бус, төрх үйлийн гүнзгий хямралтай, уналт таталт өгдөг, ухамсарт ухааны баларталтад ордог, хүний байнгын тусламж шаардагдахуйц байдалтай, бусад бие эрхтэний эмгэг согог бэрхшээл хавсран илэрсэн.
14.3	Оюуны гүнзгий хомсдол (IQ 20 хүртэл)			Оюуны коэффициент нь 20%-иас доош байна. Хэл яриа үүсч хөгжөөгүй, сэтгэхүйн үйлдлүүд

		F73	12-36 сар	огт хөгжөөгүй, ойлгох чадваргүй. Хоол ундаа барьж идэж чадахгүй, бие даан босож чадахгүй, хөдөлгөөн эрс хязгаарлагдмал байнгын хэвтэрт байна. Бие эрхтэний мэдэгдэхүйц согогууд илэрсэн.
14.4	Аутизмын хүрээний эмгэгүүд	F84, F84.2	12-36 сар	Аутизмын үнэлгээ, өдөр тутмын үйл ажиллагаа, бие даах чадвар, нийгмийн сэргээн засалт, хөгжлийн дэмжлэгт хамрагдаж байгаа зэргийг үндэслэнэ. Мөн байнгын ууртай, еертөө хандсан хэрцгий авир гаргадаг зэргийг харгалзана. Аль болох нийгмийн сэргээн засалтад хамруулна.
15. Удамшлын шалтгаантай өвчнүүд				
15.1	Удамшлын шалтгаантай өвчнүүд (Марфаны хам шинж, Тернерийн хамшинж, тодорхойгүй, Ehlers-Danlos хамшинж, Patau хамшинж, Хэврэг Х хамшинж, Rett хамшинж, Эдвард хамшинж, DiGeorge хамшинж, Cri-du-chat хамшинж, Прадер-Вилли хамшинж, Angelman хамшинж, Ehler-Danlos хамшинж, Menkes өвчин, Turner хамшинж, Homocysteinuria, Lesch-Nyhan хамшинж)	Q87.4 Q96.9 Q79.6 Q91.7 Q99.2 Q91.3 D82.1 Q93.4 Q87.1 Q93.51 Q79.6 E83.09 Q96.9 E72.1 E79.1	12-36 сар	Онош батлагдсанаас хойш хүнд хэлбэр, оюуны хомсдол үүссэн үед орно. Онош батлагдаагүй бол орохгүй. Хүнд хэлбэр нь бүх мөчдийг хамарсан хөдөлгөөний хүнд алдагдал ба таталт, танин мэдэхүйн хүнд хоцрогдол өндөр илэрсэн тохиолдолд орно.
15.2	Гликогенез /3 дугаар хэлбэр/	E74.03	12 сар	Онош батлагдсан бол орно.
16. Гэмтэл, согогийн өвчин				
16.1	Фиброзный дисплазий-Ясны эдийн дутуу хөгжлийн хүнд хэлбэр дээд доод мөчийг хамарсан	M85	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явцыг харгалзан шийдвэрлэнэ.

16.2	Нугасны хүнд хэлбэрийн гэмтэлтэй холголт, цооролт үүссэн зөөлөн эдийн их хэмжээний дутмагшилтай	S14	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явцыг харгалзан шийдвэрлэнэ.
16.3	Гэмтлийн дараах доод мөчний саажилт	G83.1	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явцыг харгалзан шийдвэрлэнэ.
16.4	Гэмтлийн дараах дөрвөн мөчний саажилт	G82	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явцыг харгалзан шийдвэрлэнэ.
16.5	Тархины хүнд хэлбэрийн гэмтэл	S00	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явцыг харгалзан шийдвэрлэнэ.
16.6	Хоёр гар аль нэг түвшинд мухар	S68	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явцыг харгалзан шийдвэрлэнэ.
16.7	Хоёр шилбэ аль нэг түвшинд мухар	S88	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явцыг харгалзан шийдвэрлэнэ.
16.8	Хоёр гуя аль нэг түвшинд мухар	S78	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явцыг харгалзан шийдвэрлэнэ.
16.9	Хоёр түнхний үеэр тайрагдсан	S78	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явцыг харгалзан шийдвэрлэнэ.
16.10	Аарцгийн хөндийн эрхтэний гэмтэлтэй хавсарсан нийлмэл хугарлууд	S70-S72	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явц, өвчний үе шат хүндрэлээс хамааран байнгын асаргаа тогтоох болон сунгана.
16.11	Дунд чөмөгний хүзүү болон гандан хэсгийн хуурамч үе үүсч ясны тэжээл, гишгэх үйл ажиллагаа алдагдсан болон бусад эрхтэн системийн үйл ажиллагааны алдагдалтай хавсарсан	S72.0	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явц, өвчний үе шат хүндрэлээс хамааран байнгын асаргаа тогтоох болон сунгана.
16.12	Түнхний үений төрөлхийн дутмаг хөгжил болон мултралыг мэргэжлийн эмчийн	Q65	12-24 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явцыг харгалзан шийдвэрлэнэ.

	хяналтанд тасралтгүй үе шаттайгаар эмчлүүлж байгаа тохиолдолд			
16.13	Түлэгдэлтийн 3 дугаар зэргээс дээш, биеийн гадаргуугийн 50% -с дээш талбай бүхий шархтай 2 ба түүнээс дээш том үений татагдаж наалдсан сорви бүхий үений өөрчлөлттэй	T20-T32	12-36 сар	Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явцыг харгалзан шийдвэрлэнэ.
17.Перинаталь үед үүссэн эмгэг				
17.1	Эх барих явцад үүссэн дээд мөчний саа саажилт (Эрб-Дюшенн)	P14.0	12 сар хүртэл	Хүнд хэлбэрийн хөдөлгөөний алдагдал болон 2 талыг хамарсан гарын саажилтын хүнд хэлбэр орно.
18.Бодисын солилцооны өвчин				
18.1	Менкесийн өвчин (арьс цайх, амархан гэмтдэг богино үс, өсөлт саатах, булчингийн хүчдэл сул-гипотони)	E83.09	12-36 сар	Оюуны хомсдол үүссэн үед орно. Сэтгэцийн эмчээр оюуны хомсдлын зэргийг тодорхойлуулсан байх.
18.2	Мукополисахаридоз	E76.3	12-36 сар	Олон эрхтэний гаж хөгжилтэй хавсардаг тул байнгын асаргаанд орно.
18.3	Муковисцидоз	E84	Мэс заслын дараа 12 сар хүртэл	Амьсгалын дутлын 3 дугаар зэрэгт орсон, диспансерийн хяналтанд тогтмол үзүүлсэн байх.
18.4	Сонгомол фенилкетонури	E70.0	12-36 сар	Хүнд хэлбэрийн хөдөлгөөн-сэтгэхүйн хөгжлийн хоцрогдол болон уналт таталтын хам шинж хавсарсан үед орно. Сэтгэцийн эмчээр оюуны хомсдлын зэргийг тодорхойлуулсан байх.
18.5	Хомоцистинури	E72.1	12-36 сар	Хүнд хэлбэрийн хөдөлгөөн-сэтгэхүйн хөгжлийн хоцрогдол болон уналт таталтын хам шинж хавсарсан үед орно. Сэтгэцийн эмчээр оюуны хомсдлын зэргийг тодорхойлуулсан байх.
18.6	Леш-Ниханы хам шинж	E79.1	12-36 сар	Хүнд хэлбэрийн хөдөлгөөн-сэтгэхүйн хөгжлийн хоцрогдол болон уналт таталтын хам шинж хавсарсан үед орно. Сэтгэцийн эмчээр оюуны хомсдлын зэргийг тодорхойлуулсан байх.

18.7	Адреногениталь хам шинж	E25.9	12-36 сар	Эрших хэлбэр, давс хаях хэлбэр, даралт ихсэх хэлбэр нь орно.
19.Арьс, харшлын өвчин				
19.1	Атопийн дерматит	L20	12 сар	Биеийн гадаргын 70% болон түүнээс дээш талбайг хамарсан, сүүлийн 1 жилийн хугацаанд 3-аас доошгүй удаа сэдэрсэн бол орно.
19.2	Хайрст үлд	L40	12 сар	Биеийн гадаргын 70% болон түүнээс дээш талбайг хамарсан, сүүлийн 1 жилийн хугацаанд 4-өөс доошгүй удаа сэдэрсэн бол орно.
19.3	Удамшлын өвчнүүд (загасан хайрстал, кератодерм, төрөлхийн цэврүүт хөрс хайлал)	L85.8 L12.3	12-36 сар	Амьдралын өдөр тутмын үйл ажиллагаа алдагдсан бол орно.
19.4	Цэврүүт өвчин (шугаман А дерматоз Хомхой хэлбэрийн дерматит цэврүүшил)	L12.8 L13.0 L12.0	12-36 сар	Биеийн гадаргын 20%, түүнээс дээш талбайг хамарсан бол орно.
19.5	Шир төст ба цагаан цэцэг төст цочмог хэвгэн үлд	L41.0	12-36 сар	Биеийн гадаргын 50%, түүнээс дээш талбайг хамарсан бол орно.
19.6	Цэврүүт хөрс хайлал	Q81.9	12-24 сар	Биеийн гадаргын 20%, түүнээс дээш талбайг хамарсан бол орно.
20.Бусад				
20.1	Ясны сийрэгжилт (хөл байнга хугарч байдаг)	M80	Онош батлагдсанаас хойш 12-36 сар	Онош батлагдаагүй бол орохгүй.

-----oOo-----